



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2023 оны 11 сарын 28-ны  
өдрийн 6481 дугаарт бүртгэв.

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,  
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2023 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Дархан-Уул аймгийн “Дархан ус суваг” ХК-ийн  
цэвэр, бохир усны үйлчилгээний тариф  
батлах тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн “Дархан ус суваг” ХК-ийн айл өрхийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг хавсралтаар баталсугай.
2. Айл өрхийн батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн хугацааны дараа сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг “Дархан ус суваг” ХК /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.
3. Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Дархан ус суваг” ХК /Г.Эрдэнэбат/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2021 оны 54 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.
5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Х.ПҮРЭВСҮРЭН

Т.УЛАМБАЯР

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН  
АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
Бүртгэлийн дугаар: 137  
**ХУУЛЬ БАР ҮНЭН**  
(Албан тушаалын нэр)  
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)  
2023. 11. 02

142310101

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны 10 дугаар сарын 27 -ны өдрийн 11.0 дугаар тогтоолын хавсралт

**Дархан-Уул аймгийн “Дархан ус суваг” ХК-ийн  
цэвэр, бохир усны үйлчилгээний тариф**

**Нэг. Хүн ам  
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	1.97
	Тоолуургүй	төг/л	2.64
	Ус түгээх байр	төг/л	2.73
Бохир ус	Тоолууртай	төг/л	2.10
	Тоолуургүй	төг/л	2.91

--o o O o o--

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН  
АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
Бүртгэлийн дугаар: ..... 157 .....  
**ХУУЛБАР ҮНЭН**  
*Арив, Билиг нарн*  
(Албан тушаалын нэр)  
*Орн*  
(гарын үсэг) ( гарын үсгийн тайлал)  
*2023.11.02*